

ОНОН-УЛЗ ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГА: .....  
/Б.БАЯРТОГТОХ/

"ДУН-ЭРДЭНЭ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ:

.....  
Л.ЛХАГВАСҮРЭН/

### УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2017 оны 06 сарын 21-ны өдөр

Дугаар 04

Баяндун сум

#### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу "Монгол Ус" төрийн өмчит үйлдвэрийн газрын гаргасан 2017 оны 06-р сарын 14-ны өдрийн № 195 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Онон-Улз голын сав газрын захиргааны олгосон 2017 оны 06-р сарын 21-ны өдрийн №А/05 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Усны ашиглуулагчийг төлөөлж Онон-Улз голын сав газрын захиргааны үйлдвэрхөдөөажухуй, ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн Барс овогтой Баяржаргал:

Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороолол, Нарны зам "Альпа төв" байрны 2-р давхар 202 тоот. Улсын бүртгэлийн №7110012035, регистрийн №2010933 дугаартай "Дун-Эрдэнэ" ХХК-ийн уурхайн гүйцэтгэх захирал Л.Лхагвасүрэн нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

#### Хоёр. Гэрээний нөхцөл:

2.1. Ус ашиглах зориулалт: Дорнод аймгийн Баяндун сумын нутагт оршиж MV-005639А тоот тусгай зөвшөөрөлтэй "Өвөлжөөт" алтны шороон орд нь технологийн хэрэгцээт усыг уурхайн ухлагаас үүсэх шүүрлийн уснаас, хүн амын унд ахуйн хэрэгцээт усыг гүний худагаас ашиглана.

#### 2.2. Ашиглах усны хэмжээ:

2.2.1. Унд ахуйд - 652 шоометр

2.2.2. Технологийн хэрэгцээнд 15.390 шоометр

2.2.3. Биологийн нөхөн сэргээлтэд - 3 640 шоометр

#### 2.3. Усны чанар, найрлага.

2017 оны 05 дугаар сарын 15, 08 дугаар сарын 15-ны өдрүүдэд шүүвэлтийн уснаас болон хаягдлын нуурнаас тус бүр 2 удаа дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг ОНОН-УЛЗ голын сав газрын захиргаанд тухай бүр албан бичгээр ирүүлнэ.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

2.4. Усны эх үүсвэрийн :

Байршил: Дорнод аймаг Баяндун сум, Түргэн баг, Өвөлжөөт нэртэй газар орших гүний худгийн усаар ажиллагсдын унд-ахуйн усны хэрэгцээг хангана.

Солбицол: E 49°32'57", N113°14'11"

Барилга байгууламж: 6150 м<sup>3</sup> багтаамжтай эргэлтийн 2 усан сангуудтай.

Тоног төхөөрөмж: Скруббер-30м<sup>3</sup>/ц-1ш, усны насос-1ш,

Хүчин чадал: Скрубберын хүчин чадал 30 м<sup>3</sup>/цаг- 1ш, Ус дамжуулах насос Д-320м<sup>3</sup>/ц -1ш

2.5. Хаягдал усны хэмжээ: Байхгүй

Хэмжээ

.....  
Стандартын шаардлага

Хаях цэгийн байршил:

Солбицол Х....., У.....

2.6. Хаягдал усанд дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг.....

Эрдэс бодис, кг.....

Хүнд металл, кг.....

Аюултай бохирдуулах бодис, кг:..... Байхгүй:.....

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

Үйлдвэрээс гарах хаягдал ус нь тунгаах нуураар дамжин тунгаагдаж, эргүүлэн үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашигладаг.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: 5.000.000 төгрөгийг Баяндун сумын Хайрхан багийн бэлчээр усжуулалтыг сайжруулах, уст цэгийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийлгэж, зураглал хийлгэх

2.9. Усны тоолуурын:

Төрөл: Байхгүй.....

Загвар:.....



Тоолуурын тоо: .....  
Суурилуулсан байгууллага, огноо: .....  
Баталгаажуулсан байгууллага, огноо: .....  
Тоолуурын заалт: .....

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: Газрын доорх усыг ашигт малтмал олборлон баяжуулах зориулалтаар ашигласан усны итгэлцүүр, хувь хэмжээгээр бодож тооцоход:

/Улз голын сав газарт газрын доорхи шүүрлийн усыг 500,4төг/шоометр/

$$15.390 \text{ шоометр} \times 500,4 = 7.701.156 \text{ төгрөг}$$

Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны төлбөрийг ногоон байгууламжид ашигласан усны итгэлцүүр, хувь хэмжээгээр тооцоход:

/Улз голын сав газарт газрын доорхи усыг 69,5 төг/шоометр/

$$3640 \text{ шоометр} \times 69,5 = 252.980 \text{ төгрөг}$$

Нийт **7.954.136** төгрөг /долоон сая есөн зуун тавин дөрвөн мянга нэг зуун гучин зургаа/

**МОНГОЛ-УС** төрийн өмчит үйлдвэрийн газрын 2017 оны 06 дугаар сарын 14- ны өдрийн №195 тоот дүгнэлтээр уурхайд шүүрэлтээр орж ирэх усны хэмжээ ашиглалтын үйл ажиллагаанд хүрэлцэхгүй, усны өөр эх үүсвэр ашиглана гэж заасан байсныг газар дээр нь танилцахад уурхайн шүүрэлтээр орж ирэх усны хэмжээ хангалттай хүрэлцэхээр байсан тул технологийн хэрэгцээнд ашиглах нийт усны хэмжээ /15.390 шоометр/-ээр тооцож усны төлбөрийг төлүүлэхээр тооцож байна.

2017 оны усны төлбөр болох долоон сая есөн зуун тавин дөрвөн мянга нэг зуун гучин зургаа /7.954.136/ төгрөгийг 07, 08, 09, 10 саруудад хуваан сар бүр 1.988.534 төгрөгийг 10-ны дотор Баяндун сумын төрийн банкны 261700124398 тоот дансанд төвлөрүүлнэ.

#### Гурав.Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талууд тохиролцсоноор гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол,

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл, холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Ус ашиглагчийг төлөөлж:

"Дун-Эрдэнэ"ХХК-ийн уурхайн дарга

*Л.Батбаатар*

Л.Батбаатар

Холбоо барих утас: 99196239

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Онон-Улз голын сав газрын захиргааны Үйлдвэр хөдөө аж ахуй, усны ашиглалт хариуцсан мэргэжилтэн

*Б.Баяржаргал*

Б.Баяржаргал

Холбоо барих утас: 88080941

И-мэйл хаяг: [bayarja1107@gmail.com](mailto:bayarja1107@gmail.com)

ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)